



**ХАВДАР СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН
2009 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**



Н.НЯМДАВААГИЙН НЭРЭМЖИТ ХАВДАР СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВ

Н.НЯМДАВААГИЙН НЭРЭМЖИТ ХАВДАР
СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2009 ОН

УЛААНБААТАР
2010.01.12

ТОВЪЁОГ

НЭГ ДҮГЭЭР БҮЛЭГ	1
БОДЛОГЫН ЗОРИЛТЫН ХЭРЭГЖИЛТ, ЯВЦ, ҮР ДҮН	1
1. ХСҮТ-ӨӨС ЗАСГИЙН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААР ХИЙСЭН АЖИЛ	1
2. ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН ТАЛААР ХИЙСЭН АЖИЛ	13
3. ЗАСГИЙН ГАЗРААС БАТАЛСАН ҮНДЭСНИЙ ХӨТӨЛӨРҮҮДИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААР ХИЙСЭН АЖИЛ	17
4. ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ, АЛБАН ДААЛГАВРЫН БИЕЛЭЛТ	22
ХОЁРДУГААР БҮЛЭГ	26
БАЙГУУЛЛАГЫН ИЛ ТОД БАЙДЛЫГ ИЛТГЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА	26
1. Үйл ажиллагааны нээлттэй, ил тод байдал	26
2. Хүний нөөцийн бодлогын ил тод байдал	31
3. Төсөв санхүүгийн ил тод байдал	36
4. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод байдал	37
ГУРАВ ДУГААР БҮЛЭГ	39
ХАВДАР СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮНЭЛГЭЭ	39
1. НИЙТЛЭГ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ	39
2. ӨВӨРМӨЦ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ	41
3. НЭМЭЛТ МЭДЭЭЛЭЛ	42
ХАВСРАЛТ	44
ХАВСРАЛТ: 1 СТАТИСТИК ҮЗҮҮЛЭЛТҮҮД	
ХАВСРАЛТ: 2 ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ	
ХАВСРАЛТ: 3 ГАДААД ХАРИЛЦАА	
ХАВСРАЛТ: 4 ТӨСЛҮҮД	
ХАВСРАЛТ: 5 СУРГАЛТ СУРТАЛЧИЛГАА	
ХАВСРАЛТ: 6 САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД	
ХАВСРАЛТ: 7 ШИНЭ ТЕХНОЛОГИ	
ХАВСРАЛТ: 8 СУДАЛГААНЫ АЖИЛ, СТАНДАРТ	
ХАВСРАЛТ: 9 ҮЙЛЧЛҮҮЛЭГЧДЭД ЭЭЛТЭЙ ОРЧИН	
ХАВСРАЛТ: 10 НИЙГЭМ, СЭТГЭЛ ЗҮЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ	
ХАВСРАЛТ: 11 ӨВДӨЛТ НАМДААХ “НАМУУН” БАГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА	
ХАВСРАЛТ: 12 ЭМЧ НАРЫН ЯРИА	
ХАВСРАЛТ: 13 УНШИГЧ КЛУБЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА	
ХАВСРАЛТ: 14 ХАТАГТАЙ КЛУБ	
ХАВСРАЛТ: 15 САНАЛ, ХҮСЭЛТИЙГ ШИЙДВЭРЛЭСЭН БАЙДАЛ	

**НЭГ. ХСҮТ- ӨӨС ЗАСГИЙН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААР
ХИЙСЭН АЖИЛ**

I БҮЛЭГ. БОДЛОГЫН ЗОРИЛТЫН ХЭРЭГЖИЛТИЙН ЯВЦ, ҮР ДҮН

1. ХСҮТ- өөс Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн талаар хийсэн ажил

ЗАСГИЙН ГАЗРЫН ЗОРИЛТ: Эрүүл мэндийн удирдлага, менежемент, эмчилгээний хяналтын тогтолцоог боловсронгуй болгон бэхжүүлнэ.

1.1 ХСҮТ-ийн удирдлага, менежментийг сайжруулах талаар

ХСҮТ нь ЭМСМТ-ний 7 үндсэн чиглэлийн дагуу байгууллагын 18 стратегийн хүрээнд үйл ажиллагаагаа төлөвлөн:

- Хавдраас сэргийлэх, хянах дэд хөтөлбөрийг үндэсний түвшинд хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлэх,
- Хорт хавдрын оношлогоо эмчилгээ, үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах,
- Байгууллагын төлөвлөлт-хяналт-үнэлгээний тогтолцоог боловсронгуй болгох,
- Ажиллагсдын нийгмийн асуудал, ажлын байрны нөхцлийг сайжруулах гэсэн зорилтуудыг дэвшүүлэн ажиллаж тавьсан зорилтоо бүрэн хэрэгжүүлж ажиллалаа.

ХСҮТ нь клиникийн зохион байгуулалтаар ажиллаж, мэс заслын болон мэс заслын бус клиник, 9 алба, 10 тасаг, оношлогоо эмчилгээний 14 кабинет, хэвтэн эмчлүүлэх 190 ор, хөнгөвчлөх тасгийн 16 ортой ажиллаж байна.

1.1.1 Хавдраас сэргийлэх, хянах дэд хөтөлбөрийг үндэсний түвшинд хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлэх зорилтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд:

- Хорт хавдраас сэргийлэх хянах дэд хөтөлбөрийг Монгол-Англи хэлээр ДЭМБ-ын санхүүгийн дэмжлэгтэйгээр 2000 хувь хэвлэж хэрэгжүүлэгч байгууллагуудад түгээхэд бэлэн болоод байна. Уг хөтөлбөрийг ДЭМБ, ОУАЭА, Номхон далайн эдийн засгийн байгууллагын олон улсын хөгжлийн хөтөлбөр /OFID/ зэрэг хандивлагч байгууллагуудад хүргүүлсэн нь олон улсын дэмжлэгтэй төсөл хөтөлбөрт хамрагдах үндэслэл боловсруулахад хэрэгцээтэй лавлагаа материал болсон юм.
- Хорт хавдраас сэргийлэх хянах дэд хөтөлбөрийн хэрэгжилтийн байдал, хорт хавдрын тусламж үйлчилгээний өнөөгийн байдалд ОУАЭА –ийн шинжээч нарын багтай хамтарч үндэсний түвшинд үнэлгээ хийсэн ба мөн ДЭМБ-ын онлайнаар өөрийн орны хавдрыг хянах хөтөлбөрийг үнэлэх гэсэн хөтөлбөрт хамрагдаж үнэлгээ хийж хүргүүлсэн болно. Цаашид 2010 онд дээрх үнэлгээний дүнг тусгаж ажиллахаар төлөвлөж байна.
- Хорт хавдраас сэргийлэх хянах дэд хөтөлбөрийг шийдвэр гаргагчид, хамтран ажиллах байгууллагууд, олон нийтэд таниулах уулзалт семинарыг 1 удаа зохион байгуулсан.
- Хорт хавдраас сэргийлэх, хянах дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг өдөр тутмын удирдлага, хяналт үнэлгээгээр хангах үүрэг бүхий олон салбарын төлөөлөлтэй техникийн ажлын хэсгийн бүрэлдэхүүн, ажлын хэсгийн удирдамж үйл ажиллагааны чиглэлийг боловсруулж ЭМЯаманд хүргүүлсэн болно.
- ХБӨ-өөс сэргийлэх хянах үндэсний хөтөлбөр, хорт хавдраас сэргийлэх хянах дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, хорт хавдрын урьдчилан сэргийлэлт, эрт илрүүлэлт, оношлогоо, эмчилгээ, хөнгөвчлөх тусламж үйлчилгээг үзүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулах

зорилгоор “Хорт хавдраас сэргийлэх, эрт илрүүлэх үйл ажиллагааны журам”, “Хавдар судлалын кабинетын ажиллах журам, ажлын байрны тодорхойлолт”, “Хорт хавдрын оношлогоонд эрүүл мэндийн шатлал тус бүрд зайлшгүй хэрэглэгдэх шинжилгээний аргууд”-ыг боловсруулж ЭМЯ-ны холбогдох алба, шийдвэр гаргагч нарт танилцуулж, ЭМС-ын удирдлагын зөвлөлд танилцуулахад бэлтгэж байна. Эдгээр бичиг баримтууд нь хавдар судлалын тусламжийг цогцоор бэхжүүлж хэрэгжүүлэхэд чиглэгдсэн болно.

- Хавдрын бүртгэл мэдээллийн журам, шинээр оношлогдсон хавдрыг бүртгэх анхан шатны маягыг боловсруулж ЭМ-ийн сайдын тушаалаар батлуулах бэлтгэл ажил хийгдэж байна. Хорт хавдрын бүртгэл мэдээллийг сайжруулах нь “Хорт хавдраас сэргийлэх хянах дэд хөтөлбөр”-ийн хэрэгжилт үр дүнг хянахад чухал ач холбогдолтой юм

1.1.2 Хорт хавдрын оношлогоо эмчилгээ, үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах зорилтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд:

- ХСҮТ-ийн захирлын 143 тоот тушаалаар ажлын хэсэг байгуулагдан хорт хавдрын оношлогоо, эмчилгээний 13 стандартыг шинээр боловсруулж, ЭМЯ-ны техникийн хороогоор хэлэлцүүлж батлуулав. 2007, 2008 онуудад батлагдсан хорт хавдар өвчний стандартыг баримтлан эмчилгээ, оношлогоог явуулж байна. Ийнхүү ХСҮТ нийтдээ хорт хавдрын оношлогоо, эмчилгээний 36 стандарттай болоод байна (*дэлгэрэнгүйг Хавсралт 8-аас үзнэ үү*).
- 2009 онд мэс заслын клиникт “Цээжний зүүн хүрцээр улаан хоолойг тайрах”, “Кен Такаскийн аргаар зүүн болон баруун элэг тайрах”, “Мезогепатэктом”, “Умайг дурангийн тусламжтайгаар үтрээний хүрцээр авах” “Эрүүний ясыг шилбэний савхан ясаар орлуулах” зэрэг хагалгаануудыг шинээр нэвтрүүллээ. Мөн 2009 оны 7 сард Монголын зүрхний холбоо, ШНЭ-ийн ангиологи эмч нартай хамтран “Зүрхний титэм судасны нарийсал тэлэх эмчилгээ”, “Пейсмекерийн аппарат суулгах эмчилгээ”-ний аргуудыг нэвтрүүллээ (*дэлгэрэнгүйг Хавсралт 7-оос үзнэ үү*).
- Мэс заслын бус клиникт 24 цагийн турш морфин дуслаар тарих, морфиныг цацлага байдлаар хэрэглэх, өвчтөний түүхэнд оруулсан нэмэлт өөрчлөлт, мөчдийн хаванг арьсан доор уян зүүг ашиглан урсгуур тавьж бууруулах, өвчтөнүүдэд зургийн болон хөгжмийн хичээл заах, зөвлөх поликлиникт архаг бронхитын үед дурангийн тусламжтай панкипсин, лидаза, гентамицинаар эмчилгээ хийх, давхар тодосгогч бодис хий үүсгэгчийг ашиглан ходоодны хорт хавдрын рентген оношлогооны чадамжийг сайжруулах, индигокармин тодосгогч бодис, ходоодны шүүрлийг багасгагч эмийн бодисыг ашиглан ходоодны хорт хавдрыг эрт үед нь оношлох аргуудыг шинээр нэвтрүүллээ (*дэлгэрэнгүйг Хавсралт 7-оос үзнэ үү*).
- Мэс заслын клиникийн эрчимт эмчилгээний тасагт “Bartain bennet-840”, “Dragger savina” амьсгалын аппаратууд, элэг цөс нойр булчирхайн мэс заслын тасагт “Элэг бяцлагч аппарат”, автомат дуслын халаагуур, цахилгаан түлэгч аппаратууд, эмэгтэйүүдийн мэс заслын тасагт гистероскопи, лапароскопийн иж бүрдэл аппаратууд, лабораторийн тасагт иммунологийн болон биохимийн автомат анализаторууд тус тус шинээр суурилагдлаа.
- Мэс заслын бус клиникийн туяа эмчилгээний тасагт зайн туяа эмчилгээний “ТЕРАГАМ” аппаратын ор болон удирдлагын программыг шинэчилж, 3 хэмжээст төлөвлөлтийн “CMS XiO” программ, хими эмчилгээний тасагт ламинар боксын систем шинээр суурилуулагдлаа. Мөн зөвлөх поликлиникт “Допплертой хэт авиагаар элэгний үүсгэврийг ялган оношлох”, “Назофарингоскопыг ашиглан толгой хүзүүний байрлалтай хорт хавдрыг оношлох” аргууд шинээр нэвтрэлээ (*дэлгэрэнгүйг Хавсралт 7-оос үзнэ үү*).

- Өвчтөний түүх, яаралтай тусламжийн хуудасны хөтлөлтөнд хяналт тавьж ажиллан илэрсэн зөрчлийг арилгах талаар эмч нарын ярианд тогтмол мэдээлэл хийж байна.
- Үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн судалгааг 2 сар тутам авч гарсан санал, шийдвэрлэвэл зохих асуудлыг захирлын зөвлөлөөр хэлэлцэж шаардлагатай арга хэмжээ авч ажиллалаа.
- Сувилахуйн тусламж үйлчилгээнд сувилагчдын гаргаж буй алдаа, зөрчлийн судалгааг 2 удаа хийж дүнг нийт сувилагчдад танилцуулж, тасгийн ахлах сувилагч болон хувь хүнтэй уулзаж алдааг дахин давтан гаргахгүй байх талаар анхаарч ажиллах заавар, зөвлөгөөг өгч ажиллав. 2009 онд ажлын хэсэг байгуулан сувилагчдын ажил дүгнэх үзүүлэлтийг шинэчлэн гаргаж, ажлаа дүгнэж байна
- Хурц болон архаг өвдөлтийг намжаах “Намуун” багийг байгуулж, хөнгөвчлөх, мэс засал, химийн тасгийн 40 гаруй өвчтөнд өвдөлт намжаах эмчилгээг хийсэн. Цаашид хурц болон архаг өвдөлтийг намжаах стандарт боловсруулах шаардлагатай байна (*дэлгэрэнгүйг Хавсралт 11-ээс үзнэ үү*).
- Дулаанд тэсвэргүй эмнэлгийн хэрэгслийг ариутгах этиленоксидын хийн ариутгалын аппаратыг суурилуулан, эмч мэргэжилтнүүдийг сурган, 2010 оноос клиникийн үйл ажиллагаанд хэрэглэх бэлтгэл ажлыг хангав.
- АНУ-ын Цацрагийн Хамгаалалтын Алба, МУ-ын ЗГ-ын хэрэгжүүлэгч Цөмийн Энергийн Газрын хамтын ажиллагааны гэрээний дагуу тус төвийн туяа эмчилгээний тасагт цацрагийн аюулгүй байдлыг хангах, хамгаалалтыг сайжруулах зорилгоор төсөл хэрэгжүүлсэн, хамгаалалтын хэрэгслүүдийг олон улсын стандартад нийцсэн түвшинд суурилуулан, байгууллагын хамгаалалтын албаны ажиллагсдад сургалт явуулан, хамтран ажиллаж байгаа ба энэ нь болзошгүй цацрагийн ослоос урьдчилан сэргийлэх том арга хэмжээ боллоо.
- Хөнгөвчлөх үеийн өвдөлт хянах, арьсан дор дуслын шингэн хийх, лимфийн зогсонгишилийн үед арьсан дор уян зүү тавих, хөхний боолт, мөчний боолт, цээжний боолт, трахеостом, колостомийн үеийн боолт хийх үйлдлийн удирдамж бичиж арга зүйн зөвлөлийн хурлаар ороход бэлтгэж байна (*дэлгэрэнгүйг Хавсралт 7-оос үзнэ үү*).
- 2009 онд Цус Сэлбэлт Судлалын Үндэсний Төвөөс боловсруулсан буй “Цус, цусан бүтээгдэхүүний стандарт” боловсруулалтын ажлын хэсгийн хэлэлцүүлэгт ХСҮТ-ээс сэхээн амьдруулахын болон хими, туяа эмчилгээний эмч нарын баг 3 удаа оролцон, хорт хавдрын үеийн цус, цусан бүтээгдэхүүний хэрэглээний өвөрмөц заалт, нөхцлийн талаарх саналуудыг тусган оруулсан ба энэ талаар илтгэл тавьж оролцов.
- ХСҮТ дээрх “CanHOPE” үйлчилгээ нь хавдартай өвчтөнүүд, тэдгээрийн ар гэр, олон нийтэд зориулсан хавдар болон түүнтэй тэмцэх талаар зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах үйлчилгээ үзүүлдэг төв ба 2009 онд нийт 821 үйлчлүүлэгчид хавдрын талаар үндсэн мэдээлэл, хавдрын үеийн хоол тэжээл, хөнгөвчлөх тусламж үйлчилгээ, урьдчилан сэргийлэлт, оношлогоо, эмчилгээтэй холбоотой мэдээлэл өгч, өвчтөн болон тэдний ар гэрт сэтгэл санааны дэмжлэг үзүүлэх, өдрийн сонинд эрүүл мэндийн боловсрол олгох нийтлэл хэвлүүлэх, зургийн цаг хөтөлбөрийг хэрэгжүүлэх чиглэлүүдээр үр дүнтэй ажиллалаа.

1.1.3 Байгууллагын төлөвлөлт-хяналт-үнэлгээний тогтолцоог боловсронгуй болгох зорилтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд:

Төлөвлөлт-Хяналт, шинжилгээ, үнэлгээний баг шинэчлэгдсэн журмын дагуу зохион байгуулагдан ажиллаж байна.

Байгууллагын жилийн үйл ажиллагааг төлөвлөхдөө дороос дээш санал авах журмыг баримтлан ажилладаг бөгөөд тасаг нэгжүүдийн жилийн ажлын төлөвлөлтийг харгалзан үздэг болно.

Ажиллагсад болон тасаг нэгжүүдийн үйл ажиллагааг дүгнэхдээ эхлээд өөрсдийн үнэлгээг хийлгэж дүнг байгууллагын хяналт -үнэлгээний баг үнэлж үр дүнг захирлын зөвлөл болон захиргааны зөвлөлд танилцуулаад тасаг нэгжүүдэд эргэн мэдээлж байна.

Тасаг нэгж, хувь хүний үйл ажиллагааг үнэлгээний дүнтэй уялдуулан хариуцлага тооцдог, урамшуулал олгодог тогтолцоог хэрэгжүүлж хэвшсэн.

1.1.4. Ажиллагсдын нийгмийн асуудал, ажлын байрны нөхцлийг сайжруулах зорилтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд:

- Нормын сүүг 142 хүнд буюу 10.0 сая төгрөг, буцалтгүй тусламж, тэтгэмжинд 4.4 сая төгрөг, нормын хувцсанд 2.1 сая төгрөг, нийт 16.5 сая төгрөг зарцуулсан ба хоол унааны хөнгөлөлтөнд 291,0 сая төгрөг тус тус зарцуулсан байна. Ажиллагсдын нийгмийн асуудлыг сайжруулах зорилгоор түрээсээр ажиллуулдаг цайны газрыг байгууллага өөрөө ажиллуулснаар ажиллагсдын хоолны үнэнд хөнгөлөлт үзүүлж байна (*дэлгэрэнгүйг Хавсралт 6-аас үзнэ үү*).
- Дулааны шугам хоолойг угаан, цахилгаан эрчим хүч бага зарцуулдаг гэрэлтүүлэг сайтай гэрлийг тасаг нэгжүүдэд суурилуулав.
- Туяа А.Б тасаг, Туяа шарлага, Эмийн сан , Эмийн сангийн агуулах, ТХМЗ, Эмэгтэйчүүд , ИТА , Дезкамер зэрэг тасаг нэгжүүдэд барилгын засвар үйлчилгээ хийгдсэн.
- 1000 гаруй мод, бут тарьж, сандал 15 ш, хогийн сав 15 ш , гэрэлтүүлэг 14 ш шинэчилж 261 м 2 талбайг чулуун хавтангаар өнгөлөн гадна талбайн тохижилтыг сайжруулав.
- Хяналтын 24 камер, дотоод сүлжээний холболтыг сайжруулан компьютерийн сүлжээнд холбогддог 8 ш хяналтын камер нэмж суурилуулав.
- “Хатагтай клуб”-ыг ажиллагсдын нийгмийн болон сэтгэлзүйн асуудалд дэмжлэг үзүүлэх зорилгоор 2009 онд Нэгдсэн гал тогооны албыг түшиглэн байгуулсан ба нийт 3 удаагийн үйл ажиллагаа явуулаад байна. Клубын үйл ажиллагаа Бямба гаригт зохион байгуулагддаг ба ажлын бус цаг тул оролцогсод өөр хоорондоо чөлөөтэй ярилцан, бие биенээсээ туршлага солилцон, суралцсан зүйлээ бодит байдлаар хийж үздэг давуу талтай (*Хавсралт 14-өөс зураг үзнэ үү*).
- Ажилчид болон үйлчлүүлэгчдийн хоолны үйлчилгээний зохион байгуулалт, чанарыг сайжруулах төлөвлөгөө гарган Амтат, Зөөлөн нэртэй хоолны өдөрлөгийг зохион байгуулж, эмчилгээний хоолны түгээлтийн системийг өөрчлөх судалгааны ажлуудыг хийж хэрэгжүүлж эхэлсэн (*Хавсралт 10-аас зураг үзнэ үү*).
- 2009 оны 08 сарын 18-ны өдрийн засгийн газрын тогтоолоор ХСҮТ-ийг "Намхай-Очирын Нямдаваагийн нэрэмжит" болгох шийдвэр гарсаны дагуу Хавдар Судлалын Үндэсний Төв Намхай-Очирын Нямдаваагийн нэрэмжит боллоо. Энэ нь хавдар судлалын салбарт ажиллаж буй эмч, эмнэлгийн ажилтан хамт олны урам зоригийг сэргээсэн ач холбогдолтой ажил боллоо (*Хавсралт 2-оос зураг үзнэ үү*).

1.2 Гадаад харилцааг хөгжүүлэх талаар

1.2. 1. ОУ-ын болон гадаадын байгууллагуудтай хийсэн хамтын ажиллагаа

- ОУАЭА-ийн ерөнхийлөгч Эль Барадэй ХСҮТ-д айлчилж эрүүл мэндийн чиглэлээр Монгол Улсын Засгийн Газрын ЭМЯ-тай хамтран ажиллах ,

хавдрын эмчилгээний хөтөлбөрийн багийг Монгол Улсад ажиллуулах талаар тохиролцов. Үүний дагуу ОУАЭА-ийн мэргэжилтнүүдийн баг 7, 10 дугаар сардуудад ХСҮТ-д нийт 3 удаа ирж ажиллаж, хорт хавдрын өвчлөл, эндэгдэл, тусламж, үйлчилгээний өнөөгийн байдалтай танилцаж, ЭМЯ, Цөмийн Энергийн Газар, ДЭМБ-ын мэргэжилтнүүдтэй уулзалт хийв. Мөн “Хорт хавдраас сэргийлэх, тэмцэх дэд хөтөлбөр”-ийн хэрэгжилтийн байдлын үнэлгээтэй танилцаж, Улаанбаатар хотын Хан-Уул, Баянзүрх дүүргүүдийн эрүүл мэндийн төв, Төв аймгийн нэгдсэн эмнэлэг, Сэргэлэн сум, Дархан-Уул аймгийн Хонгор сум, аймгийн нэгдсэн эмнэлэг, өрхийн эмнэлэг, зарим Хосписын хавдрын тусламж, үйлчилгээ үзүүлж байгаа байдлыг бодит байдлаар үзэж, үнэлгээнийхээ дүнг Эрүүл мэндийн дэд сайд, стратеги төлөвлөлтийн газар, АНУ-ын мянганы сорилын сангийн төлөөлөгчид оролцсон уулзалтад танилцуулж, ярилцсан болно. Үүний үр дүнд хавдартай тэмцэх хөтөлбөр болон бүтцийг бэхжүүлэх сайжруулах, цаашдын бодлого, хавдартай тэмцэх дэд хөтөлбөр болон түүний хэрэгжилттэй холбоотой нэн тэргүүний алхмуудыг тодорхойлж хавдартай тэмцэх үйл ажиллагаатай холбоотой төсөл хэрэгжүүлэх боломжийг судалсан юм (*Хавсралт 2-оос зураг үзнэ үү*)

- ЭМЯ, Цөмийн Энергийн Газар, ХСҮТ-ийн төлөөлөгчид ОУАЭА-ийн 53-р ерөнхий бага хуралд оролцож “Хорт хавдрын өвчлөл, нас баралт, тусламж үйлчилгээний өнөөгийн байдал” сэдвээр илтгэл тавив.
- “Амьд донороос элэг шилжүүлэн суулгах” хагалгааг дэлхийд анх удаа хийсэн, элэгний мэс заслын тэргүүлэх мэргэжилтэн гэж үнэлэгддэг, “Элэгний мэс заслын судалгааны олон улсын төв”-ийн ерөнхийлөгч М.Макуучи манай төвийн урилгаар 2009 оны 6 сард 3 хоног зочлон, “Орчин үеийн элэгний мэс заслын ололт амжилт” лекц уншсан ба лекцийн үеэр “Элэг тайрах” мэс заслыг ХСҮТ-ийн эмч нартай хамтран хийж буй үйл ажиллагааг лекцийн танхимд шууд дамжуулан үзүүлсэн. Энэ арга хэмжээнд томоохон эмнэлгүүдийн дотрын болон мэс засалч 50-иад мэргэжилтэн оролцсон. Мөн энэ айлчлалын үеэр доктор М.Макуучи МУ-ын ерөнхий сайд, Эрүүл Мэндийн Яамны сайдтай уулзалт хийж, элэгний мэс заслыг цаашид хөгжүүлэх боломж, нөхцлийн талаар ярилцан, 2011 оноос ХСҮТ-ийг “Элэгний мэс заслын төв”-тэй болгох талаар санал солилцсон (*Хавсралт 3-аас зураг үзнэ үү*).
- АНУ-ийн Миннесота мужийн Дулуть клиникийн мэс засалч их эмч Парк-Скайнертэй 10 хоногийн турш хамтран ажилласан ба энэ хугацаанд хөхний өмөнгийн оношлогоо эмчилгээний талаар туршлага солилцон, хөхний мэс засалд 10 удаа хамтран орж, хөхний хэт авиан шинжилгээг 56 өвчтөнд хийж, зөвлөгөө өгч ажиллалаа. Мөн энэ үеэр МУ дах АНУ-ын элчин сайдын яамны “Олон нийттэй харилцах албатай” хамтран “Хөхний хортой хавдрын оношлогоо эмчилгээний орчин үеийн чиг хандлага” сэдвээр семинар амжилттай зохион байгуулсан.
- Швейцарын мэс засалчдын багтай хамтран ажиллаж буй үйл ажиллагааны шугамаар мэс заслын эмч Pr. Gillet, Dr. Chanson, анестезиологи эмч Dr. Warner нар ХСҮТ-ийн мэс заслын клиникт нэг сар хамтран ажиллаж, 60 орчим хагалгааг хамтран хийв.. Мөн Швейцар, Францын эмч нартай хамтран умайн хөндийн дурангийн оношлогоо, дурангийн мэс засал хийгдсэн. Хамтран ажилласнаар эмч нарын онолын мэдлэг болон ур чадвар дээшилсэн. Мөн энэ үеэр “Швейцарын мэс засалчдын баг”-аас ХСҮТ-д 70.000 гаруй долларын мэс заслын багаж хэрэгсэл, элэгний мэс заслын үед нэн шаардлагатай аппарат болох “Cusa dissectron”-ыг автомат дуслын халаагч, force-FX коагуляцын аппарат зэргийн хамт хандивлав (*Хавсралт 2,3-аас зураг үзнэ үү*).

- Тайваны Үндэсний Их Сургуулийн төлөөлөгчид төвийн үйл ажиллагаатай танилцан, харилцан танилцуулга илтгэл тавьж, ярилцан, 2010 онд хамтарсан семинар, теле конференц зохион байгуулахаар тохиролцсон ба цаашид хоёр талын мэргэжилтнүүдийг харилцан солилцох талаар ярилцаж байгаа (*Хавсралт 3-аас зураг үзнэ үү*).
- “Ротари” клубын 2008-09 оны захирал Донг Курн Ли тус төвд айлчилсан ба төвийн үйл ажиллагаатай танилцан, цаашид хөрөнгө оруулалтыг дэмжих талаар уулзалт ярилцлага хийв.
- “Баянзүрх Ротари” клубээс 140.000.000 төгрөгний үнэ бүхий эмэгтэйчүүдийн хавдрын үед дурангийн оношлогоо, эмчилгээ хийх боломж бүхий лапароскопийн иж бүрдэл хандивласан ба 2009 оны 10 сард суурилуулагдан үйл ажиллагаанд орсноос хойш 20-иод өвчтөний оношлогоо, эмчилгээнд үр дүнтэй хэрэглээд байна (*дэлгэрэнгүйг Хавсралт 4-өөс үзнэ үү*).
- “Солонгосын Эд Эс Судлалын Нийгэмлэг”-тэй хамтран “Эс судлал-2” сэдэвт семинарыг зохион байгуулж хот хөдөөгийн 30 орчим эмгэг судлаач эмч нар оролцов.
- Германы ЭСЯ-ны ажилтан Патрик Кройцийн санаачлагаар 2000 орчим ам долларын эмнэлгийн хэрэгсэл болон өвчтөний асаргаа сувилгаанд зориулсан нэг удаагийн хэрэгслүүд цугларсан ба хөнгөвчлөх эмчилгээний тасагт хэвтэн эмчлүүлж буй өвчтөнүүдэд хандивласан. Мөн энэ хандивын аяныг үргэлжлүүлэхээр харилцан зөвшилцөн, хөнгөвчлөх эмчилгээний өвчтөнүүдэд нэн шаардлагатай байдаг ахуйн хэрэглээний болон асаргааны зүйлсийн хэрэгцээг тодорхойлсон судалгаа гаргаж өгсөн.

1.2.2. Амжилттай хэрэгжсэн төслүүд

- Швейцарын мэс засалчдын багийн бүрэлдэхүүнд ирж ажилласан эмгэг судлалын профессор Оберхолтцтэй 2 удаагийн уулзалт хийж, эд эс судлалын шинжилгээний алсын зайн оношлогооны талаар зөвлөлдөн, Люксенбург, Швейцарийн хамтын ажиллагааны байгууллагын шугамаар телемедицинийн сүлжээг нэгтгэх төслийн хүрээнд 20.000 ам долларын тоног төхөөрөмжүүдийг суурилуулан, үйл ажиллагааг эхлүүлэв.
- Япон улсын доктор Нагата Нацуме-ийн ХСҮТ-ийн бүртгэл мэдээллийн хүчин чадлыг нэмэгдүүлэх зорилгоор хандивласан 5000 ам долларын хөрөнгө оруулалтаар компьютер, хэвлэх төхөөрөмж, вирусын эсрэг програмын хамтаар иж бүрэн суурилуулав (*дэлгэрэнгүйг Хавсралт 4-өөс үзнэ үү*).
- Швейцарын мэс засалчдын багийн дэмжлэгтэйгээр тээврийн зардал 3.000 ам долларыг шийдвэрлэн, өвчтөний 100 орыг шинэчлэв.
- АНУ-ын Цацрагийн Хамгаалалтын Алба, МУ-ын ЗГ-ын хэрэгжүүлэгч Цөмийн Энергийн Газрын хамтын ажиллагааны гэрээний дагуу тус төвийн туяа эмчилгээний тасагт 69.000 ам.долларын төсөл хэрэгжиж, цацрагийн аюулгүй байдлыг хангах, хамгаалалтыг сайжруулах зорилгоор цацраг идэвхт үүсгүүр бүхий туяа эмчилгээний аппарат бүрийн бункерт хяналтын камер, дуу хөдөлгөөн мэдрэгч, дуут дохиолол, хамгаалалтын хаалга зэргийг олон улсын стандартад нийцсэн түвшинд суурилуулав.
(*дэлгэрэнгүйг Хавсралт 4-өөс үзнэ үү*).

1.2.3. Цаашид хэрэгжүүлэхээр бэлтгэсэн төслүүд:

- ОУАЭА-ийн ерөнхийлөгч Эль Барадэйн ХСҮТ-д хийсэн айлчлал болон ОУАЭА-ийн мэргэжилтнүүдийн баг 3 удаа ирж ажиллан, үнэлгээ хийсний үр дүнд ХСҮТ ОУАЭА-ийн “Хавдрын эмчилгээний хөтөлбөр”-ийн “Загвар орон” төсөлд хамрагдах асуудал 2010 оны эхний улиралд шийдвэрлэгдэх

боломж бүрдлээ.

- Австри улсын “Vamed” эрүүл мэндийн корпорацид ЭМЯ-ы дэмжлэгтэйгээр 8 сая ам.долларын “ХСҮТ-ийн оношлогооны чадамжийг сайжруулах нь” төслийг боловсруулан хүргүүлээд байгаа ба шинжээчдийн баг 2 удаа ирж амжилттай ажиллан, 2010 оны 3-р сард тус корпорацийн удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцэхээр болоод байна (*дэлгэрэнгүйг Хавсралт 4-өөс үзнэ үү*).
- Хөдөө орон нутгийн хүн амд хавдрын тусламж үйлчилгээг сайжруулах, өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх зорилгоор хавдрын нарийн мэргэжлийн явуулын үзлэг оношлогооны чадамжийг сайжруулах “Нефть импортлогч орнуудын хамтын ажиллагаа”-ны “Грант” төслийн хүрээнд 400,000 ам долларын төслийг 2009 оны 11 сард боловсруулж илгээсэн.
- “Таван Богд Косметик” ХХК-ны санаачлагаар хамтран ажиллах гэрээ байгуулж, Люксембургийн ЭСЯ-д “Хөхний хорт хавдраас урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэлт” сэдвээр төсөл илгээсэн нь дэмжигдэн, 10.000 еврогийн санхүүжилт авах болсон ба үйл ажиллагааны хамтарсан төлөвлөгөө гарган, 2010 онд хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.
- “Баянзүрх Ротари” клубт хандан, “Ангиографийн аппаратны тусламжтай эмчилгээ үйлчилгээний чадамжийг сайжруулах”, “Хими эмчилгээг чадавхижуулах”, “Эхо оношлогооны тусламжтай элэгний хорт хавдрын эрт илрүүлэлтийг сайжруулах” сэдэвт 80.000 орчим ам.долларын өртөг бүхий 3 төслийг хүргүүлээд байна.

(*дэлгэрэнгүйг Хавсралт 4-өөс үзнэ үү*)

ЗАСГИЙН ГАЗРЫН ЗОРИЛТ: Эрүүл аж төрөх хэв маяг, эрүүл мэндээ хамгаалах зан үйлийг төлөвшүүлж хүн амын өвчлөл, нас баралтыг бууруулж дундаж наслалтыг уртасгана.

2.1 ХСҮТ-ийн Нийгмийн эрүүл мэндийн мэдээллийн төвд зохион байгуулсан үйл ажиллагаа

“Эрүүл чийрэг хүүхэд насаа хайрлая”, “Умайн хүзүүний хорт хавдраас сэргийлье”, “Хорт хавдрын урьдчилан сэргийлэлт”, “Тамхи ба хавдар”, “Стресс ба хорт хавдар” зэрэг сэдвүүдээр 12 удаа өдөрлөг зохион байгуулж нийт 2500 хүнд хавдраас сэргийлэх талаар сурталчилгаа хийж хорт хавдраас сэргийлэх, эрт илрүүлэх чиглэлээр 2000 гаруй суртчилгааны материалыг иргэдэд түгээсэн (*Хавсралт 5-аас зураг үзнэ үү*).

2.2 “Хорт хавдраас сэргийлье” сэдэвт 14 хоногийн аян

Өдөрлөг болон нээлттэй хаалганы өдрөөр ард иргэдийн дунд элэгний хавдраас сэргийлэх, умайн хүзүүний хавдраас сэргийлэх, зохистой хооллолт, бухимдлаас гарах аргууд зэрэг нийт 500 гаруй сурталчилгааны материал тараасан. Хөхний хавдар умайн хүзүүний хавдраас сэргийлэх талаар 14 хоногийн хугацаанд сурталчилгааны кино гаргасан (*Хавсралт 5-аас зураг үзнэ үү*). Эмчилгээний хоолны талаар “Зохистой хоол-Эрүүл мэнд” өдөрлөгийг 2009 оны 11-р сарын 13-нд Нэгдсэн гал тогоо Амос ТББ-тай хамтран зохион байгуулж өдөрлөгийн үеэр Амос ТББ эрүүл амьдрах 8 зарчим өртөөчилсөн зөвлөгөө болон хэрхэн зохистой зөв хооллох талаар сургалт лекц явуулсан бөгөөд НГТ төрөл бүрийн хоолны үзэсгэлэн гаргалаа. Нийт 50 орчим үйлчлүүлэгч оролцон, 10 төрлийн /эрүүл амьдрах, хавдраас сэргийлэх, зохистой хоол, эмчилгээний хоол хэрхэн бэлтгэх г/м гарын авлага/ 100 ширхэг гарын авлага тараагдсан.

2.3 Нээлттэй хаалганы өдөр :

Нээлттэй хаалганы өдрийг графикайн дагуу **12 удаа** зохион байгуулж нийт **1405** өвчтөнд сурталчилгаа хийж үнэ төлбөргүй сувилахуйн тусламж үзүүлсэн. **230** үйлчлүүлэгчдээс сэтгэл ханамжийн судалгаа авсан. **1750** ширхэг хавдрын сурталчилгааны материалыг тараасан.

2.4 Телевизээр хийсэн суртчилгаа :

MTV – 5 удаа, TV 9 – 3 удаа, UBS – 3 удаа, ТМ – 3 удаа, Боловсрол TV – 3 удаа,

TV – 5 – 2 удаа нийт **19 удаагийн** нэвтрүүлэгт **21** эмч оролцож хавдраас сэргийлэх, хавдар өвчин үүсгэгч эрсдэлт зан үйлээс зайлсхийх, эрт илрүүлэх чиглэлээр олон нийтэд мэдээлэл, мэргэжлийн эмчийн зөвлөгөө өгсөн.

2.5 Сонинд нийтлүүлсэн материалууд:

Өдрийн сонинд - “Ходоодны хавдраас сэргийлье”, өглөөний сонинд –“Монголд хавдрын эрсдэл аюултай хэмжээнд хүрээд байна” нийтлэл, Зууны мэдээ сонинд “Элэгний хатууралтай хүнд хоолны дэглэм маш чухал”, “Монголд хавдрын оношлох, эмч нарынх нь ур чадвар хаана ч гологдохгүй болсон” сэдэвт ярилцлага нийтлэл, Монголын мэдээ сонинд - зайн шарлагын аппаратны талаар тодруулга, Өнөөдөр сонин, Монголын цахилгаан мэдээ сонин, Үндэсний шуудан сонинд – Хавдар өвчнөөс сэргийлэх талаар сурталчилгааны үзүүлэлт бүхий материалууд, Хүмүүсийн амьдрал сонинд ярилцлага зэрэг Нийт **9 сонинд 10 эмчийн** ярилцлага болон сурталчилгааны материал нийтлэгдсэн (*Хавсралт 5-аас зураг үзнэ үү*).

2.6 Радиоогоор

FM102 , 107.5 – 2 удаагийн ярилцлага
FM102 – 1 удаа ярилцлага тус тус хийсэн болно.

2.7 Сувилагчийн нэг өдөр

Сувилагчийн нэг өдөр өдөрлөгийг сард 2 удаа нийт 24 удаа “ Хавдраас урьдчилан сэргийлье”, “Охид эмэгтэйчүүдийн эрүүл ахуй”, “Сүрьеэгийн халдвараас сэргийлье”, “Хөхний хавдраас сэргийлэх нь” зэрэг сэдвүүдээр сургалт, сурталчилгаа хийсэн. 650 гаруй хүнд сургалт сурталчилгаа хийж, сувилахуйн зөвлөгөө өгч ажилласан. “Хорт хавдраас сэргийлэх, эрт илрүүлэх”, хавдартай өвчтний оношлогоо, эмчилгээ, асаргаа сувилгаа, хооллолтын талаарх мэдээллийг боловсруулж “Танд зөвлөх нь” сэдэвт хавтсыг тасаг бүрт ажиллуулж хэвтэн эмчлүүлэгсэд ар гэрийнхэнд нь уншуулж байна..

Хавдрын үеийн гэрийн сувилахуй сэдвээр зөвлөмж бэлдэж арга зүйн зөвлөлөөр хэлэлцүүлэхээр бэлэн болгосон. Эдгээр зөвлөмжийг үйлчлүүлэгчид хүргэснээр гэрийн нөхцөлд өөрийгөө арчлах мэдлэг, чадвар дээшилнэ.

ЗАСГИЙН ГАЗРЫН ЗОРИЛТ: Хүн амын эрүүл мэндийн мэдээллийн цахим сан байгуулна. Эмнэлгийн цахим сүлжээ, алсын зайн оношлогоо, эмчилгээг өргөжүүлэн иргэн бүрт эрүүл мэндийн үйлчилгээг шаардлагатай түвшинд үзүүлэх бололцоог хангах зорилгоор анагаах ухааны орчин үеийн ололтод тулгуурласан төрөлжсөн мэргэжлийн төвүүдийг хөгжүүлж өвчнийг эрт оношлох, эмчлэн, нөхөн сэргээх чадавхийг дээшлүүлнэ.

3.1 ХСҮТ-ийн цахим сүлжээний талаар.

3.1.1 ХСҮТ-ийн амбулаторийн 11 кабинет, үйл оношлогооны хэсэг СТ, рентген, ЭХО, ангиографийн кабинетууд, лаборатори, сүлжээнд холбогдоод байна. Цахим дугаар зохицуулагч системийг эрүүл мэндийн байгууллагуудын анхдагч болж ХСҮТ нэвтрүүлээ. Ийнхүү амбулаторийн тасгаар үйлчлүүлж буй үйлчлүүлэгчдэд зориулсан хүлээлгийн цогц систем хэрэгжиж эхэлснээр үйлчлүүлэгчдэд нээлттэй, түргэн шуурхай, эмх цэгцтэй үйлчилгээг хүргэх, цахим бүртгэлийн болон амбулаторийн эмч, ажилчдын өдөр тутмын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж байна. Мөн 100 хэрэглэгч бүхий дотуур холбооны системийг хэрэглэж байгаа нь төвийн дотоод мэдээллийг шуурхай болгох ач холбогдолтой боллоо.

3.1.2 ХСҮТийн веб сайтыг шинэчилж сайжруулан монгол, англи хэлээр байрлуулан умайн хүзүү, хөх, элэгний хавдраас сэргийлэх, зөв хооллолт, хавдрын зарим гол нийтэд хамааралтай үзүүлэлтийн талаар мэдээллийг байрлуулан үйл ажиллагааг тогтмолжуулснаар ХСҮТ-ийн веб сайтад одоогоор 24000 гаруй хүн хандаад байна. Энэ нь веб сайтыг ашиглан олон нийтэд мэдээллийг хүргэх хямд, шуурхай үр ашигтай юм байна гэдгийг үзүүлж байна (*Хавсралт 5-аас зураг үзнэ үү*).

3.1.3 ХСҮТ-ийн гол байрлалуудад хяналтын 24 камер байрлуулж, дотоод

сүлжээний холболтыг сайжруулан компьютерийн сүлжээнд холбосон нь ач холбогдолтой байна. Шинээр 8 ш хяналтын камер нэмж суурилуулав.

ЗАСГИЙН ГАЗРЫН ЗОРИЛТ: Тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжтэй нягт уялдуулан эрүүл мэндийн санхүүжилтийн тогтолцоог шинэчилж эрүүл мэндийн даатгалын сангийн үйл ажиллагааг боловсронгуй болгоно.

4.1.2009 оны төсөвт эдийн засгийн хямралтай байгааг үндэслэн, төсвийн тодотгол хийж, цалингийн санг батлагдсан орон тоонд тохируулан ажиллаж байна.
4.2.Эмийн төсөв 243 сая төгрөгөөр буурсан ч эмийн татан авалт бүрэн хийгдэж, эмийн өр авлага гаргалгүй ажилласан.
4.3.Байгууллагын өмч хамгаалах зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн , дотоод хяналтыг сайжруулан, мөнгөн хөрөнгөнд хяналт тавин төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийг хэрэгжүүлэн ажиллаж байна.
4.4.ЭМД-ын хуулинд өөрчлөлт оруулах саналыг ЭМЯ-д өгсөн. “Өртөг ойролцоо оношийн бүлэг” -ээр санхүүжүүлэх тогтолцоог хэрэгжүүлж байгаа нь үр дүнтэй байна.
4.5.Сангийн яам болон ЭМЯаманд нэмэлт тусламж үйлчилгээний санхүүжилтийн талаар бусад эмнэлгүүдтэй хамтран санал явуулснаар тухайн асуудлыг шийдвэрлүүлэн ажиллаж байна.

ЗАСГИЙН ГАЗРЫН ЗОРИЛТ: Эмч эмнэлгийн ажилтны мэдлэг, ур чадварыг тасралтгүй дээшлүүлж ёс зүйн хариуцлагыг өндөржүүлнэ.

5.1. 2009 онд оношлогоо, эмчилгээний 13 стандартыг шинээр боловсруулах, дахин нэмэлт өөрчлөлт оруулахаар ХСҮТ-ийн захирлын 143 тоот тушаалаар ажлын хэсгийг байгуулан, стандартуудыг боловсруулан ЭМЯ-ны техникийн хороогоор хэлэлцүүлж батлуулав.Хорт хавдрын оношлогоо, эмчилгээний нийт 36 стандарттай болоод байна (*дэлгэрэнгүйг Хавсралт 8-аас үзнэ үү*).

5.2 “Эмнэлгийн үйлчилгээнд цээрлэвэл зохих 7 нүгэл” “ Таагүй мэдээг хүргэх нь”, “Хэцүү өвчтөн”, “Эмнэлгийн алдаа” сэдвээр нийт 4 удаа ёс зүйн сургалтыг нийт эмч, сувилагч нарт явуулав. Давхардсан тоогоор 420 гаруй эмч, сувилагч, тусгай мэргэжилтнүүд нарыг сургалтанд хамруулав байна (*дэлгэрэнгүйг Хавсралт 12-оос үзнэ үү*).

5.3 Резидент эмчийн гарын авлага, сорилын номыг баяжуулан шинэчлэн хэвлэлтэнд бэлтгэсэн. ХСҮТ-ийн эмч мэргэжилтнүүдийн гадаад дотоодод мэргэжил дээшлүүлэх журмыг шинэчлэн боловсруулж, уг журмыг боловсруулах ажлын хүрээнд 2009-2011 онд эмч мэргэжилтнийг сургах 3 жилийн төлөвлөгөөг батлуулж хэрэгжүүлж байна. Хавдар судлаач эмчийн резидентурын сургалтаар 4 эмчийг төгсгөв.

5.4 2009 онд ХСҮТ-ийн 40 эмч мэргэжилтэн 52 удаа урт, богино хугацаагаар гадаадад /Австри, Япон, USA, ОХУ, Малайз, Тайвань, БНХАУ, БНСУ, Египет, Герман, Итали, Сингапур/ мэргэжил дээшлүүлсэн. Үүнээс:

- 5 захиргааны ажилтан,
- 27 их эмч
- 2 эм зүйч
- 1 эм найруулагч
- 2 статистикч бага эмч
- 3 инженер

5.5. Ажиллагсдын компьютерийн мэдлэгийг дээшлүүлэхийн тулд ээлжийн 17 сувилагчид сургалт зохион байгуулж, хэрэглээний программууд дээр ажиллах чадварыг сайжруулав

5.6 “Цацрагийн ослын үед авах арга хэмжээ, сэргийлэлт менежмент” сэдвээр хийх үзүүлэх сургалтын төлөвлөгөөг гарган бэлтгэл ажлыг ханган, ОБЕГ, Цацрагийн хяналтын албатай хамтран үзүүлэх сургалтыг амжилттай зохион байгууллаа. Сургалтын үеэр эмч, эмнэлгийн ажилчид, инженер техникийн ажилтнуудад цацрагийн хордлогын үед авах арга хэмжээ, эмчилгээний талаар хичээл заав

	байна (<i>Хавсралт 2-оос зураг үзнэ үү</i>). 5.7 “Журнал клуб”-ын үйл ажиллагаа 2 чиглэлээр тогтмол явагдаж хэвшээд байгаа ба Мэс заслын клиникт 8 удаа, Мэс заслын бус клиникт 12 удаа тус тус хийгдээд байна (<i>дэлгэрэнгүйг Хавсралт 13-аас үзнэ үү</i>). 5.8 Баасан гараг бүр эмч нарын яриа тогтмол зохион байгуулагдаж хэвшсэн бөгөөд 36 удаа хийгдэж, орчин үеийн шинэ арга технологи танилцуулах, өндөр хөгжилтэй оронд суралцаад ирсэн эмч нар туршлагаа хуваалцах зэрэг хэлбэрүүдээр нийт 50 төрлийн мэдээлэл хийгдсэн байна (<i>дэлгэрэнгүйг Хавсралт 12-оос үзнэ үү</i>). 5.9. Сувилагчдын мэдлэг мэргэжлийг дээшлүүлэх талаар байнга анхаарч ажилладаг бөгөөд 2009 онд шинээр 21 сувилагч “Төвийн итгэмжит сувилагч” болсон байна.
--	--

ЗАСГИЙН ГАЗРЫН ЗОРИЛТ: Хүн амын эрүүл мэндийн эрэлт хэрэгцээнд тулгуурласан эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг хэрэгжүүлж, практик үр өгөөжийг дээшлүүлнэ.

	6.1 ХСҮТ-ийн эрдмийн зөвлөл ХСҮТ-н захирлаар батлуулсан төлөвлөгөөний дагуу ажиллаж байна. Эрдмийн зөвлөлийн хурлыг 3,6,12 сард нийтдээ 3 удаа хийж, мэс заслын эмч нарыг мэс заслын арга барилд сургах талаар үр бүтээлтэй ажилласан Швейцарын эмч Чансонд ХСТ-н Хүндэт доктор цол олгох асуудлыг хэлэлцэж шийдвэрлэв байна (<i>Хавсралт 2-оос зураг үзнэ үү</i>). Г. Пүрэвдоржийн “Төвөнхийн хучуур эсийн гаралтай хавдруудын хавсарсан эмчилгээг төгөлдөржүүлэх нь” сэдэвт докторын зэрэг горилох ажлын сэдэв аргачлал, “Хорт хавдрын эрт илрүүлэлтийн эдийн засгийн үр ашгыг тооцох аргачлал”, ОУАЭА-с хэрэгжүүлж буй “Нөөц бололцоо дутмаг оронд хүүхдийн туяа эмчилгээг сайжруулах” судалгааны ажлын явц үр дүнг хэлэлцэж, зөвлөгөө өгөв байна (<i>дэлгэрэнгүйг Хавсралт 8-аас үзнэ үү</i>). 6.2 “Монгол хүн амын дунд зонхилон тохиолдох хорт хавдраар өвчилсөн хүмүүсийн амьдрах чадварын судалгааны аргачлал” боловсруулж, АУХ-ийн эрдмийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж батлуулсан. 6.3 Хорт хавдрын эрт илрүүлэлтийн эдийн засгийн үр ашгийн тооцоо” судалгааны ажлыг аргачлалын дагуу хийж, дээрх сэдвээр эрдэм шинжилгээний өгүүлэл бичиж, Монголын Анагаах Ухаан сэтгүүлийн 2009 оны №1-д хэвлүүлсэн байна. Үр дүнг АУХ-н эрдмийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, үнэлгээ авсан болно (<i>дэлгэрэнгүйг Хавсралт 7-оос үзнэ үү</i>). 6.4. ХСҮТ-өөс эрхлэн эрдэм судлалын чиглэлээр болон нийтэд зориулсан “ХАВДАР СУДЛАЛ” сэтгүүлийг гаргаж хэвшлээ. 6.5. Токиогийн эмэгтэйчүүдийн анагаах ухааны их сургуулийн профессор Ямомота нарын 25 хүний бүрэлдэхүүнтэй баг ХСҮТ, бусад клиникийн эмч нар оролцсон “Хоол боловсруулах замын эрхтэнүүдийн зарим төрлийн хорт хавдрын эмчилгээний орчин үеийн чиг хандлага” сэдэвт олон улсын семинарыг амжилттай зохион байгуулав. Семинарт нийт 250 орчим эмч мэргэжилтнүүд оролцлоо байна (<i>Хавсралт 3-аас зураг үзнэ үү</i>). Токиогийн эмэгтэйчүүдийн анагаах ухааны их сургуулийн гастроэнтерологийн төв, Накаяамагийн хавдар судлалын институтын эмч хүрэлцэн ирж нэг хоногийн хамтарсан семинар, мэс засал хийв. Мэс заслын клиникийн удидагч Я.Эрдэнэ-Очир “Монгол дахь ходоодны хорт хавдрын мэс засал эмчилгээний түвшин” сэдвээр илтгэл тавилаа. Мөн Япон улсын Чига их сургуулийн мэс заслын тасгийн их эмч Хисахиро Мацубаратай хамтран “Тотальная гастрозектомия” мэс заслыг хийв. Уг мэс заслыг хагалгааны өрөөнөөс семинарт оролцогчдод шууд дамжуулан үзүүллээ. Солонгосын “Эд, Эс Судлалын Нийгэмлэг”-тэй хамтран, “Эс судлал-2” сэдэвт семинарыг зохион байгуулж, хот хөдөөгийн 30 орчим эмгэг судлаач эмч нар оролцов. 6.6. 2009 онд тус төвийн их эмч Э.Амарсанаа “Хөхний өмөн үүсэхэд нөлөөлөх зарим эрсдэлт хүчин зүйл” сэдэвт судалгааны ажлаар, их эмч Р.Асай “Хөхний
--	---

	өмөнгийн рентген (маммографи) оношлогооны асуудалд” сэдэвт судалгааны ажлаар тус тус Анагаах Ухааны Докторын зэрэг амжилттай хамгааллаа. 6.7. ОУАЭА-аас зохион байгуулсан “Туяа эмчилгээн дэх орчин үеийн арга техник” сэдэвт 79 орны 382 төлөөлөгч оролцсон олон улсын конференцид тус төвийн ажилтан “Туяа эмчилгээний 2 хэмжээст төлөвлөлтийн хавдрын болон төлөвлөлтийн эзэлхүүнийг 3 хэмжээст төлөвлөлтийнхтэй харьцуулсан нь” сэдэвт илтгэл тавьсан.
--	--

ЗАСГИЙН ГАЗРЫН ЗОРИЛТ: Улаанбаатарт телемедицины төв байгуулна.

7.1. Телемедицины сургалтанд ХСҮТ-ийн компьютерийн сүлжээний инженер, сургалтын арга зүйч нар оролцож, зайнаас оношлогоо, эмчилгээний талаар зөвлөгөө өгөх, мэдээлэл солилцоход зориулагдсан CAMPUS MED программд суралцсанаас гадна Люксембург, Швейцарийн хамтын ажиллагааны байгууллагын шугамаар телемедицины сургалт, эмнэлзүй, клиникийн цахим иж бүрдэл компьютер, принтер, бичил харуур, дижиталь зургийн аппарат зэрэг 20,000 еврогийн үнэтэй тоног төхөөрөмжийг сургалтын алба, лаборатори, клиникийн менежерийн өрөөнд байрлуулж зарим БОЭТ, аймагтай мэдээлэл солилцож хавдрын өндөр нарийн мэргэжлийн зөвлөгөөт тусламжийг алсын зайнаас өгөх нөхцөл бүрдээд байна.

2. Эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн талаар хийсэн ажил

2.1 Санхүүгийн хууль, журмын хэрэгжилтийн талаар:

2.1.1. Нягтлан бодох бүртгэлийн хууль, Төсвийн байгууллагын удирдлага санхүүжилтийн тухай хууль, Нэгдсэн төсвийн тухай хууль, Эрүүл мэндийн даатгалын хууль болон бусад хууль, тогтоомж, журам, заавар тогтоомжийн дагуу НББүртгэлийн бодлогын 15 хавсралт бүхий баримт бичгийг боловсруулан ХСҮТ-ийн санхүү бүртгэл, эдийн засгийн үйл ажиллагаанд мөрдлөг болгон ажиллаж байна.

2.1.2. Санхүүгийн тайлангаар шийдвэр гаргахаар сонирхогч гадны болон дотоодын хэрэглэгчдэд шаардлагатай үндсэн мэдээллээр тогтмол хангаж байгаа бөгөөд тус төвийн НББүртгэлийн бодлогын баримт бичгийн 9-р хавсралтаар санхүүгийн тайланг гаргаж хэвшүүлсэн болно.

2.1.3. Бүтээгдэхүүний өртөг, зардлын бүртгэлийн тогтолцоог сайжруулах зорилгоор “Санхүүгийн мэдээлэл” товхимлыг улирал бүр гаргаж, удирдлагад мэдээлэн, үр дүнг тооцдог. Сангийн Сайдын 2006 оны 11-р сарын 27-ны 388-р тушаалын 4-р хавсралт буюу Төсвийн байгууллагын бүтээгдэхүүний өртөг тооцох аргачлалыг судлан бүтээгдэхүүнд суурилсан удирдлагын тогтолцоонд шилжих бэлтгэл ажлыг хийж байна

2.1.4. Мөнгөн болон биет хөрөнгийн нөөцийг зөв зохистой ашиглах хамгаалах талаар Сангийн сайдын 123-р тушаалын дагуу Төсвийн байгууллагад мөрдөгдөх мөнгөн кассын ажиллагааны журам, Төрийн сангийн төлбөр тооцооны журам, Төсвийн зарцуулалтын эрхийн тухай журам, Төрийн сангийн бэлэн мөнгөний төлбөр тооцоог гүйцэтгэх журам тус бүрийг баримтлан мөн 2009 оны 6-р сарын 22 ны Сангийн сайдын 147 тоот тушаалыг мөрдөн ажиллаж байна

2.1.5. Эрүүл мэндийн сайдын 2006 оны 8-р сарын 21-ний 277-р тушаал Төлбөртэй үзүүлэх тусламж, үйлчилгээний жагсаалт, журам, ЭМСайд, Сангийн Сайдын хамтарсан 2006- оны 11-р сарын 23-ны 370/387 тоот тушаал ЭМБайгууллагад нэмэлтээр үзүүлэх тусламж үйлчилгээний журам тус бүрийг баримтлан, байгууллагын төлбөрт үйлчилгээний журманд өөрчлөлт оруулан шинэчилсэн.

2.1.6.Дотоод хяналтын системийг тус төвийн НББүртгэлийн бодлогын баримт бичгийн 8-р хавсралтын дагуу хэрэгжүүлэн ажиллаж, үндсэн хөрөнгөнд бүртгэлээр тавих хяналтыг сайжруулав. Сайдын 2009 оны 6-р сарын 5-ны 135 тоот тушаал буюу “Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн дахин үнэлээ хийх” аргачлалын дагуу байгууллагын үндсэн хөрөнгөнд дахин үнэлгээ хийх ажлын комисс байгуулан ажиллав.

2.1.7.Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 зүйл 4 дэх хэсэг, Засгийн газрын 2008 оны 78,168 дугаар тогтоол, тус төвийн захирлын 180 тоот тушаалыг үндэслэн байгууллагын 2009 оны үндсэн хөрөнгийг хяналтын тооллого явуулах ажлын хэсэг төлөвлөгөө гарган ажилласнаар Төрийн Өмчийн хороонд материалыг бүрэн хүргэж, ТӨХорооны 2116 тогтоолоор 40.9 сая төгрөгний үндсэн хөрөнгийг 2009 оны 4-р улиралд багтаан шийдвэрлээд байна

2.1.8.Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийн 38.1 дүгээр зүйлийн дагуу Санхүүгийн тайланг тогтмол хугацаанд нь гаргаж санхүү татварын байгууллагад хүргүүлэн, татвар төлөлтийн өр, зөрчилгүй ажилласан.

2.1.9.ХСҮТөвийн 2009 оны хэрэгцээт эм, эмнэлгийн хэрэгсэл нийлүүлэх гүйцэтгэгчээр* Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэгч сонгох журмын тухай* хуулийн 34.2т заасны дагуу нийт тендерийн гэрээ ,мөн хуулийн 34.1.2, 30,4,2-т заасны дагуу шууд ба хязгаарлагдмал гэрээ хийн тендерийн гэрээтэй ажиллаж байна.

2.2. Нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааы талаар:

2.2.1.Тус төвийн санхүүгийн тайлан нь Нягтлан бодох бүртгэлийн шаардлагуудтай нийцсэн,стандартад шаардсан зарчмын дагуу нягтлан бодох бүртгэлийн аккрузл суурийг хэрэглэсэн .

2.2.2. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль,Засгийн газрын 2001 оны 134 тоот тогтоол,Төрийн өмчийн хорооны 562 дугаар тогтоол, СЭЗСайдын 2002 оны 292-р тушаалын дагуу түрээслэгч байгууллагатай түрээсийн гэрээ байгуулан Төрийн өмчийн хороонд бүртгүүлэн баталгаажуулж,түрээсийн орлогын 20%ийг сар бүр тооцон улсын төсөвт төвлөрүүлэн төлж өр авлагагүй ажилласан.ТӨХорооны 2007 оны 2-р сарын 8-ны 42 тоот тушаалын дагуу түрээсийн төлбөрийн 1м2 ашигтай талбайн үнийг үндэслэн шинэчилсэн. 2009 онд түрээсийн орлогын шимтгэл 8.3 сая төгрөгийг ТӨХороонд төвлөрүүлэн ажиллалаа.

2.2.3. Төрийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах үйл ажиллагаа нь: Засгийн газрын 2009 оны 93 тоот тогтоол, Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 33.1,33.2-р зүйл (харьцуулалтын аргаар), мөн 2006,02,15-ны өдрийн Засгийн газрын тогтоол №22, Сангийн сайдын худалдан авах ажиллагаанд баримтлах тусгай журам, тус төвийн өмч хамгаалах болон худалдан авах комиссын шийдвэрийг үндэслэн явагдаж байна.

2.2.4. 2009 онд шинээр нэмэгдсэн үндсэн хөрөнгийг зохих журмын дагуу Нягтлан бодох бүртгэлд бүрэн тусган, төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн хүрээнд тооллогыг тогтоосон хугацаанд нь тоолов. 2009 онд төсвийн ба өөрийн хөрөнгөөр 18,4 сая төгрөгний,тусламж хандиваар 389,4 сая төгрөгний, ЭМЯамны хөрөнгө оруулалтаас тоног төхөөрөмжийн их засварт 151,7 сая төгрөгний,2008 оны хөрөнгө оруулалтаас суурилагдаагүй байсан 357,6 сая төгрөгний , ЭМЯамны хөрөнгө оруулалтаас 66,3 сая төгрөг буюу нийт 2009 онд 625,9 сая төгрөгний эмнэлгийн тоног, төхөөрөмж, үндсэн хөрөнгийг данс бүртгэлд тусган бүртгэв (дэлгэрэнгүйг Хавсралт 5-аас үзнэ үү).

2.2.5. Нягтлан бодох бүртгэл болон өмч хөрөнгийн эзэмшил, хадгалалт хамгаалалтанд бүртгэлээр тавих хяналтыг сайжруулан тооллого, тооцоог тогтоосон хугацаанд нь явуулан үр дүнг тооцон ажиллалаа.

2.3. Цалин хөлсний талаар:

2.3.1. Монгол Улсын Засгийн газрын “Төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан тушаалын ангилал зэрэглэлийг шинэчлэн тогтоох тухай” 2007 оны 9-р сарын 27 ний өдрийн 236 дугаар тогтоол, “Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, доод жишгийг шинэчлэн тогтоох тухай”, 2007 оны 9-р сарын 27-ны 237 дугаар тогтоол, Монгол Улсын Засгийн Газрын 1995 оны 95 тоот тогтоол Хүн амын бодлого хөдөлмөрийн сайд, Сангийн сайдын 1996 оны 63/104 тоот тушаал, ХСҮТөвийн ҮЭ ийн хороо, захиргааны хооронд байгуулсан хамтын гэрээ зэргийг үндэслэсэн ХСҮТөвийн бүтцэд хамаарах ажлын байр, орон тоонд ажиллах эмч ажилтнуудын цалингийн хэмжээний тухай захирлын тушаалаар цалин хөлсийг олгож байна.

2.3.2. Цалин хөлсөнд мөрдөгдөж буй журам:

Ажиллагсдын цалин хөлс олгохдоо Монгол Улсын Хөдөлмөрийн хууль болон Хавдар Судлалын Үндэсний Төвийн захирлын тушаалаар баталсан доорхи журмыг мөрдлөг болгодог. Үүнд:

1. Төвийн хөдөлмөрийн дотоод журам
2. Ажлын цаг ашиглалт, цагийн бүртгэлийн журам
3. Харилцаа хандлагын нэмэгдэл олгох журам
4. Хариуцлагын нэмэгдэл олгох журам
5. Төвийн захиргаатай ҮЭХорооноос хийсэн хамтын гэрээ
6. Төвийн хяналт, шинжилгээ, үнэлгээний журам эдгээр болно.

2.4. Хавдар Судлалын Үндэсний Төвийн нэмэлт болон төлбөртэй үйлчилгээний талаар:

2.4.1. “Эрүүл мэндийн тухай” Монгол улсын хуулийн 21-ийн 5-р заалт, Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 12-ын 4.6-р заалт, Эрүүл мэнд, Сангийн Сайдын хамтарсан 2006 оны 370/387 тоот тушаалыг үндэслэн тус төвийн захирлын тушаалын дагуу нэмэлт тусламж, үйлчилгээг явуулж байна. Мөн ЭМЯамны 1а19/70 тоот албан бичгийн дагуу ЭМСайдын батласан “Төрөлжсөн нарийн мэргэжлийн эмнэлэг, төвүүдийн 2009 оны нэмэлт тусламж үйлчилгээнээс олох орлого”-ын санхүүжилтийг Сангийн яамны төрийн сангаар дамжуулан хянуулан орлогыг төрийн санд бүрэн төвлөрүүлж, эрхээ нээлгэн үйл ажиллагаагаа явуулав.

2.4.2. Төлбөртэй тусламж үйлчилгээ болон нэмэлт тусламж үйлчилгээний орлогоос журмын дагуу эмч ажиллагсдад 2009 онд 132.5 сая төгрөгний урамшуулал олгосон нь 2008 онтой харьцуулахад 17.5%-иар өссөн байна.

2.4.3. Төлбөрт тусламж үйлчилгээний орлого, нэмэлт тусламж үйлчилгээний орлогыг эдийн засагчаар хянуулан, зарцуулах төсөв болон ажиллагсдын урамшууллыг тасаг нэгжийн хурлын протоколыг үндэслэн төвийн захирлаар баталгаажуулж, цалин болон тасаг нэгжийн хэрэгцээнд бичиг хэрэг аж ахуйн зардалд зарцуулан, хяналтын механизмыг бүрдүүлэн ажиллаж байна. Төлбөрт тусламж үйлчилгээний орлого, нэмэлт тусламж үйлчилгээний орлогын санхүүжилтийн эрхийг Сангийн Яамны Төрийн сангаар нээлгэн зарцуулав.

3. Засгийн газраас баталсан үндэсний хөтөлбөрүүдийн хэрэгжилтийн талаар

Монгол Улсын ЗГ-ын 246-р тогтоолоор батлагдсан “Халдварт бус өвчнөөс сэргийлэх, хянах үндэсний хөтөлбөр, ЗГ-ын 224-р тогтоолоор батлагдсан “Эрүүл аж төрөх зан үйлийг төлөвшүүлэхэд чиглэсэн мэдээлэл, сургалт, сурталчилгааг эрчимжүүлэх зарим арга хэмжээний тухай”, “Тамхины хяналтын хууль” 2005 он,” ЭМС-ын 210 тоот тушаалаар батлагдсан “Хорт хавдраас сэргийлэх, хянах дэд хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд доорхи ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

3.1 ХБӨ-өөс сэргийлэх, хянах үйл ажиллагааг удирдан зохицуулах тогтвортой механизмыг бүрдүүлэх талаар

3.1.1. Хорт хавдрын өвчлөл нас баралтыг бүртгэх, хянах механизмыг сайжруулах зорилгоор “Хорт хавдрын бүртгэл, мэдээллийн нэгдсэн удирдамж”-ийг бүртгэлийн хамрах хүрээ, хорт хавдрыг мэдээлэх үндэслэл ба хяналт, мэдээний эх сурвалж, мэдээний урсгал явц, мэдээний агуулга, мэдээнд хэрэглэгдэх ангилал, мэдээний чанарын шалгуур үзүүлэлт, бүртгэлийн системд хэрэглэгдэх программ хангамж, хэвлэх мэдээлэх, хүний нөөцийн асуудал гэсэн хэсгүүдтэйгээр боловсруулагдсан Хавдар судлалын мэргэжлийн зөвлөл, холбогдох мэргэжилтнүүдийн саналыг аван ЭМЯ-д хүргүүлээд байна. Ажлын хэсгийн уулзалтыг 8 удаа зохион байгуулж давардсан тоогоор 144 хүн оролцож ажилласан ба удирдамжийн төслийг үндэсний түвшинд 2 удаа хэлэлцүүлж хавдар судлалын мэргэжлийн зөвлөл, эрдмийн зөвлөлөөр хэлэлцүүлсэн.

3.1.2. Хорт хавдрын бүртгэл мэдээллийн талаар /IARC/ Олон улсын хорт хавдрын бүртгэл, судалгааны төвтэй холбогдон ажиллаж олон улсын **GLOBOCAN** төсөлд хамрагдаж Монгол улсын хорт хавдрын өвчлөлийн мэдээллийг мэдээлж байхаар зөвшөөрөгдөөд байна.

3.1.3. Хорт хавдрын бүртгэл, мэдээллийн талаар аймаг, дүүргийн хавдар судлаач эмч, статистикч эмч нарын төлөөлөл оролцуулсан 2 өдрийн сургалт, хорт хавдрын бүртгэл, мэдээллийн нэгдсэн удирдамжийн төслийг хэлэлцүүлэх уулзалт семинарыг зохион байгуулж нийт 30 статистикч их эмч болон хавдар судлаач эмч нар оролцлоо /ЭМҮХТ-1, НЭМГ-1 БОЭТ-3, дүүргийн 15, ХСҮТ – 10/.

3.1.4. Халдварт бус өвчнөөс сэргийлэх хянах үндэсний хөтөлбөрийн хүрээнд хавдрын тусламж үйлчилгээний өнөөгийн байдлыг үнэлэх ажлын үнэлгээний аргачлалыг ХСҮТ-ийн сургалт арга зүйн зөвлөлөөр батлуулан санамсаргүй түүвэрлэлтийн аргаар сонгогдсон хавдартай 40 өвчтөн, өрхийн эмч, сумын эмнэлгийн эмч, дүүргийн эрүүл мэндийн нэгдлийн эмч, аймгийн нэгдсэн эмнэлгийн эмч ХСҮТ болон бусад төрөлжсөн нарийн мэргэжлийн клиникийн нийт 70 эмчээс асуумжийн болон дагаж судлах аргаар хавдартай өвчтөнүүдэд тусламж үйлчилгээг хэрхэн үзүүлж байгаа талаар үнэлгээ хийж дүнг ХСҮТ-ийн эрдмийн зөвлөлөөр хэлэлцүүлсэн.

3.1.5. Хорт хавдрын тусламж үйлчилгээний талаар үндэсний түвшинд мөрдөх журмыг

- Хорт хавдрыг бүртгэх, мэдээлэх удирдамж
- Хорт хавдартай тэмцэх техникийн ажлын хэсгийн дүрэм
- Хорт хавдраас урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үйл ажиллагааны журам
- Хавдар судлалын тасгийн ажиллах журам, ажлын байрны тодорхойлолт
- Хорт хавдрын оношлогоонд эрүүл мэндийн шатлал тус бүрд зайлшгүй

хэрэглэгдэх шинжилгээний аргууд зэрэг бүрэлдэхүүнтэй боловсруулж хавдар судлалын мэргэжлийн зөвлөл, эрдэмтэд зөвлөхүүдийн саналыг авч төслийг ЭМЯ-д хүргүүлсэн.

3.2 Эрүүл амьдралын хэв маяг, ээлтэй орчныг дэмжсэнээр ХБӨ-ний эрсдэлт хүчин зүйлсийн түвшинг бууруулах талаар

3.2.1 Дэлхийн хавдартай тэмцэх өдөр 2009.02.04 “ Эрүүл чийрэг хүүхэд насаа хайрлая” сэдэвт уриан дор доорхи ажлуудыг зохион байгуулсан.

Дэлхийн хавдартай тэмцэх өдөр 2009.02.04 “ Эрүүл чийрэг хүүхэд насаа хайрлая” сэдэвт уриан дор доорхи ажлуудыг зохион байгуулсан (*Хавсралт 5-аас зураг үзнэ үү*).

- Хүүхдийн хорт хавдар, хорт хавдраас урьдчилан сэргийлэх талаар материал боловсруулж хэвлэлд бэлтгэн нийтлүүлсэн.
- “Ардын эрх”, “Өглөөний сонин” “Монголын мэдээ” сонинуудад хүүхдийн хорт хавдар, хорт хавдраас урьдчилан сэргийлэх талаар сонинд сурталчилгааны нүүр хэвлүүлсэн.
- “АХА” нэвтрүүлэгт явуулахтай холбогдуулж хорт хавдрын урьдчилан сэргийлэлт эрт илрүүлэлтийн талаар асуулт хариулт болон нэвтрүүлгийн дундуур бичгээр явах сурталчилгааны материал боловсруулж бэлтгэсэн.
- ЭМШУИС, “Хавдар судлаач оюутаны нийгэмлэг”, “СЭМҮҮН” студитэй хамтарч ЭМШУИС-ийн оюутнуудын дунд хорт хавдраас сэргийлэх талаар “АХА” нэвтрүүлгийг ТВ-ээр явуулсан ба нэвтрүүлгийн явцад бичгээр нэг цагийн сурталчилгаа явуулсан.
- Хүүхдийн хорт хавдар, хорт хавдраас урьдчилан сэргийлэх талаар шинээр сурталчилгааны материал боловсруулж 1000 ш хэвлүүлсэн.
- Хүүхдийн хорт хавдар, хорт хавдраас урьдчилан сэргийлэх талаар лекц зохион байгуулж 100 гаруй оюутан, өсвөр насны хүүхдийг оролцуулсан ба сурталчилгааны материал түгээж сурталчилгааны самбар ажиллуулсан.

3.2.2. Умайн хүзүүний хорт хавдраас сэргийлье сэдэвт өдөрлөг

- НЭММТөвд ЭМШУИС болон 84-р сургуулийн 60-аад сурагчид оролцож умайн хүзүүний хавдрын тухай лекцэнд хамрагдсан. Сурталчилгааны кино гаргаж санамж зөвлөмж материал 250 тараасан. Д.Оюунчимэг М.Сувдмаа нар MTV, TMTV телевизээр “ Умайн хүзүүний хорт хавдраас сэргийлье” сэдвээр ярьсан. Өдрийн сонинд сурталчилгааны нүүр гаргасан.

3.2.3. “ Хорт хавдрын урьдчилан сэргийлэлт эрт илрүүлэлт” сэдэвт өдөрлөг

- Их эмч Р.Асай “Хөхний хавдраас сэргийлье” Д.Баярмаа “хавдрын урьдчилан сэргийлэлт эрт илрүүлэлтийн талаар”, Ж.Оюунчимэг “Ходоодны хавдрын дурангийн шинжилгээгээр илрүүлэх нь”, Д.Мөнхцэцэг “Амны хөндийн хорт хавдраас сэргийлье” сэдвээр лекц уншсан. БЗД-ийн 14,15 хорооны нийт 70 иргэд оролцож сурталчилгааны материал санамж зөвлөмж 270 тараасан. Сувилахуйн үнэ төлбөргүй тусламж үзүүлсэн.

3.2.4. Улаанбаатар хот үүсэн байгуулагдсаны 370 жилийн ойг угтаж Баянзүрх дүүрэг “Эрүүл мэнд, биеийн тамир спортын жишиг дүүрэг” болох нээлтийн өдөрлөг

- Өдөрлөгийн ажиллагаанд ХСҮТ-өөс ЭШСМАлбаны дарга Д.Оюунчимэг ахлагчтай багийн гишүүд оролцож байгууллагаа сурталчлах болон хавдраас сэргийлэх талаар ард иргэдийн дунд сурталчилгааны ажил хийсэн. Өдөрлөгийн үеэр хавдар судлаач эмчийн зөвлөгөө, зохистой

хооллолтын талаар зөвлөгөө, эмийн зохистой хэрэглээний талаар зөвлөгөө, сувилахуйн тусламж үйлчилгээ ард иргэдийн дунд зохион байгуулж 120-иод хүнд зөвлөгөө өгсөн (*Хавсралт 5-аас зураг үзнэ үү*). Мөн ард иргэдэд ХСҮТ-ийн үйл ажиллагааг танилцуулж, хавдар өвчнөөс хэрхэн урьдчилан сэргийлэх талаар сурталчилгааны материалууд, хөхний хавдраас сэргийлэх хөхөө өөрөө шалгах аргачлал, элэгний хавдраас сэргийлье, умайн хүзүүний хавдраас хэрхэн сэргийлэх вэ, зөвхөн танд, нийгмийн эрүүл мэндийн мэдээллийн төвийн сурталчилгааны хуваарь зэрэг нийт 350 ширхэг сурталчилгааны материал, хавдар судлал сэтгүүлийн 2000 – 2006 оны дугаарууд 30 ширхгийг тараасан.

3.2.5. Тамхи ба хорт хавдар сэдэвт өдөрлөг

- АМОС ТББ болон МСТН хамтран хийсэн. "Тамхины хор" сэдэвт баримтат кино үзүүлж амьсгалын дасгал хөдөлгөөнийг 30 хүнд зааж сургасан. Мөн уушигны хорт хавдраас хэрхэн сэргийлэх талаар хошин шогийн үзүүлбэр үзүүлсэн.
- Оролцогчдын амьсгалын багтаамжийг хэмжиж өртөөчилсөн хэлбэрээр "Health expo" өдөрлөгийг 8 өртөөгөөр зохион байгуулж ард иргэдэд зөвлөгөө өгсөн. АМОС ТББ болон МСТН хамтран зохион байгуулсан ба сайн дурын 65 идэвхтэн гишүүд оролцсон.

3.2.6. "Стресс ба хорт хавдар" сэдэвт өдөрлөг НЭММТөв

- ЭШСМА –аас "Гэгээ" ТББ, "Сэтгэлийн хүч" ТББ хамтран "Бясалгал болон хоол эмчилгээний талаар" лекц, "Стресс ба хорт хавдар" сэдвээр тайвшралын лекц бүхий хөтөлбөртэйгээр зохион байгуулсан ба нийгмийн ажлын дадлагажигч оюутнууд болон хавдартай өвчтөн, иргэд 105 хүн оролцсон. Энэ үеэр 10 төрлийн санамж, зөвлөмжийг 300 ширхэгийг тараасан.

3.2.7. "Хорт хавдраас сэргийлье" сэдэвт 14 хоногийн аян

- ЭШСМАлба, ЭДХА, Лабораторийн тасаг, Нэгдсэн гал тогооны тасаг зохион байгуулсан. Өдөрлөг болон нээлттэй хаалганы өдрөөр ард иргэдийн дунд элэгний хавдраас сэргийлэх, умайн хүзүүний хавдраас сэргийлэх, зохистой хооллолт, бухимдлаас гарах аргууд зэрэг нийт 500 гаруй сурталчилгааны материал тараасан. Хөхний хавдар умайн хүзүүний хавдраас сэргийлэх талаар 14 хоногийн хугацаанд сурталчилгааны кино гаргасан. Эмчилгээний хоолны талаар "Зохистой хоол-Эрүүл мэнд" өдөрлөгийг 2009 оны 11-р сарын 13-нд Нэгдсэн гал тогоо Амос ТББ-тай хамтран амжилттай зохион байгууллаа. Өдөрлөгийн үеэр Амос ТББ эрүүл амьдрах 8 зарчим өртөөчилсөн зөвлөгөө болон хэрхэн зохистой зөв хооллох талаар сургалт лекц явуулсан бөгөөд НГТ төрөл бүрийн хоолны үзэсгэлэн гаргалаа. Нийт 150 гаруй үйлчлүүлэгч оролцон, 10 төрлийн /эрүүл амьдрах, хавдраас сэргийлэх, зохистой хоол, эмчилгээний хоол хэрхэн бэлтгэх г.м/ 100 ширхэг гарын авлага тараагдсан.

3.2.8. Нээлттэй хаалганы өдөр:

- Нээлттэй хаалганы өдрийг графикийн дагуу **12 удаа** зохион байгуулж нийт **1405** өвчтөнд суртчилгаа хийж үнэ төлбөргүй сувилахуйн тусламж үзүүлсэн. **230** үйлчлүүлэгчдээс сэтгэл ханамжийн судалгаа авсан. **1750** ширхэг суртчилгааны материалыг тараасан.

3.2.9. Телевизээр хийсэн суртчилгаа:

- MTV – 5 удаа, TV 9 – 3 удаа, UBS – 3 удаа, TM – 3 удаа, Боловсрол TV – 3 удаа, TV – 5 – 2 удаа,

Нийт **19 удаагийн** нэвтрүүлэгт **21** эмч оролцсон.

3.2.10. Тамхины хяналтын хуулийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд

- Тамхины хайрцган дээр санамж боловсруулах үндэсний ажлын хэсэгт ХСҮТ-ээс оролцож ажилласан ба дээрхи санамж нь ДЭМБ-ын шалгаруулалтанд тэргүүн байрыг эзэлсэн тул ДЭМБ-ын Ерөнхий захирлын хүндэт өргөмжлөлөөр ХСҮТ-ийн ажилтан шагнагдсан.

3.3. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг сайжруулах талаар

4. Эрүүл мэндийн сайдын тушаал, албан даалгаврын биелэлт

3.3.1. Хорт хавдрын оношлогоо эмчилгээний 13 стандартыг боловсруулж батлуулсан (*дэлгэрэнгүйг Хавсралт 7-оос үзнэ үү*).

3.3.2. Зонхилон тохиолдох хорт хавдрын оношлогоо эмчилгээний стандартыг танилцуулах 3 өдрийн сургалтанд зохион байгуулж хот хөдөөгийн 65 эмч оролцсон.

3.3.3. Мэс заслын өмнөх ба дараах сувилахуйн тусламжийн удирдамж 7, хими эмчилгээний үеийн сувилахуйн тусламжийн удирдамж 8-ийг боловсруулан сургалт мэргэжил арга зүйн зөвлөлөөр хэлэлцүүлэн батлуулсан.

3.3.4 Хими эмчилгээний үеийн сувилахуйн тусламжийн удирдамжийн талаар нийт 100 сувилагчдыг 14 хоногийн сургалтанд хамруулсан.

3.3.5 “ Хоол боловсруулах тогтолцооны зарим хорт хавдруудын оношлогоо эмчилгээний орчин үеийн ололтууд”сэдэвт олон улсын эрдэм шинжилгээ, онол практикийн бага хурал ХСҮТ-ийн Нийгмийн Эрүүл Мэндийн Мэдээллийн Төвд 2009.04.30 – 2009.05.01 өдрүүдэд болсон.

3.3.6 2009 онд мэс заслын клиникт “Цээжний зүүн хүрцээр улаан хоолойг тайрах”, “Кен Такаскийн аргаар зүүн болон баруун элэг тайрах”, “Мезогепатэктомии”, “Умайг дурангийн тусламжтайгаар үтрээний хүрцээр авах” “Эрүүний ясыг шилбэний савхан ясаар орлуулах” зэрэг хагалгаануудыг шинээр нэвтрүүлээ. Мөн 2009 оны 7 сард Монголын зүрхний холбоо, ШНЭ-ийн ангиологи эмч нартай хамтран “Зүрхний титэм судасны нарийсал тэлэх эмчилгээ”, “Пейсмерийн аппарат суулгах эмчилгээ”-ний аргуудыг нэвтрүүлээ (*дэлгэрэнгүйг Хавсралт 6-аас үзнэ үү*). Мэс заслын бус клиникт Туяа эмчилгээ 2 хэмжээстээс 2.5 хэмжээстэд шилжсэн, Хими эмчилгээнд битүүмжлэгдсэн ламинар бокст урсгалд шилжсэн. Мэс заслын клиникт мэс заслын 5 шинэ арга нэмэгдсэн. Мэс заслын бус клиникийн туяа эмчилгээний тасагт зайн туяа эмчилгээний “ТЕРАГАМ” аппаратын ор болон удирдлагын программыг шинэчилж, 3 хэмжээст төлөвлөлтийн “CMS XiO” программ, хими эмчилгээний тасагт ламинар боксын систем шинээр суурилуулагдлаа. Мөн зөвлөх поликлиникт “Допплертой хэт авиагаар элэгний үүсгэвэрийг ялган оношлох”, “Назофарингоскопыг ашиглан толгой хүзүүний байрлалтай хорт хавдрыг оношлох” аргууд шинээр нэвтэрлээ (*Дэлгэрэнгүйг Хавсралт 7-оос үзнэ үү*).

№	Огноо Дугаар	Хаанаас хэнээс ирсэн	Товч утга	Аль хэлтэс, тасгийн хэнд шилжүүлсэн	Хэрхэн шийдвэрлэсэн
1	12.19 277	ЭМ-ийн сайд С.Ламбаа	Шагнах тухай	Санхүү эдийн засгийн албаны дарга Х.Нарантуяа	Сайдын тушаалын дагуу “Эрүүлийг Хамгаалахын Тэргүүний ажилтан” хүндэт тэмдгээр 3 ажилтан, “Эрүүлийг Хамгаалахын Хүндэт жуухаар” 9 ажилтанд тус тус шагнагдав.
2	3.03 69	ЭМ-ийн сайд С.Ламбаа	2009 оны олон улсын сувилагчдын өдөр тэмдэглэх удирдамж батлах тухай	Клиник эрхэлсэн дэд захирал Г.Навчаа, Сувилахуйн албаны дарга Д.Дуламсүрэн	ОУ-ын сувилагчдын өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын төлөвлөгөө гарган, төсөв батлуулан, захирлын тушаал гарган ажилласан. Энэ ажлын хүрээнд байгууллагын урлагийн үзлэг зохион байгуулж, сувилагчдын баярын өдрөөр хүндэтгэлийн гала концерт тоглов. Мөн “Сувилагч таны итгэлтэй анд” сэдэвт хавдраас урьдчилан сэргийлэх сэдвээр нээлттэй хаалганы өдөрлөг зохион байгуулж, 60 үйлчлүүлэгчид хавдраас сэргийлэх мэдлэгийн түвшин тогтоох судалгаа хийв. Онол практикийн бага хурал зохион байгуулж, шилдэг 12 илтгэлийг хэлэлцүүлсэн.
3	3.10 76	ЭМ-ийн сайд С.Ламбаа	Мэдээлэл, сургалтын төвийг ашиглах тухай	Эрдэм шинжилгээ сургалт эрхэлсэн дэд захирал Г.Пүрэвсүрэн	ЗГ-ын 224 тоот тушаалын дагуу ХСҮТөвийн Нийгмийн Эрүүл Мэндийн Мэдээллийн Төвд нийт 7 удаагийн сургалт, мэдээллийн ажил зохион байгуулж 1000 гаруй хүмүүс оролцсон байна.
4	5.01 133	ЭМ-ийн сайд С.Ламбаа	Томуугийн А хүрээний (H1N1) шинэ вирусийн халдвараас сэргийлэх, бэлэн байдлыг хангах тухай	Клиник эрхэлсэн дэд захирал Г.Навчаа	Нийт эмч, ажиллагсдын мөрдөх түр журам, бэлэн байдлыг хангах ажлын хэсэг байгуулан, заавар тушаалыг батлуулан, томуугийн А хүрээний (H1N1) шинэ вирусийн цар тахлын үеийн бэлэн байдлыг хангах төлөвлөгөө гарган ажилласан.
5	5.12 149	ЭМ-ийн сайд С.Ламбаа	Эхийн эндэгдлийг бууруулах арга хэмжээний тухай	Эрдэм шинжилгээ сургалт эрхэлсэн дэд захирал Г.Пүрэвсүрэн	Эхийн эндэгдлийг бууруулах арга хэмжээний тухай холбогдох мэргэжилтнүүдэд танилцуулав.
6	4.10 114	ЭМ-ийн сайд С.Ламбаа	Ажлын хэсэг байгуулах тухай	Эрдэм шинжилгээ сургалт эрхэлсэн дэд захирал Г.Пүрэвсүрэн	Цахим мэдээллийн санг бүрдүүлэх ажлын хэсэгт тогтмол оролцож, шаардлагатай мэдээ, мэдээллээр хангаж ажиллаж байна.

7	5.22 160	ЭМ-ийн сайд С.Ламбаа	Анагаах ухааны хүрээлэнгийн талаар авах арга хэмжээний тухай	Эрдэм шинжилгээ сургалт эрхэлсэн дэд захирал Г.Пүрэвсүрэн	Анагаах ухааны хүрээлэнгийн талаар авах арга хэмжээний тухай холбогдох мэргэжилтэн, албан хаагчдад танилцуулав.
8	4.24 132	ЭМ-ийн сайд С.Ламбаа	Сувилахуйн удирдлага, зохион байгуулалт ыг боловсронг уй болгох тухай	Хүний нөөцийн менежер П.Мөнхзул	Сувилахуйн удирдлага зохион байгуулалтаа бүтэц, үлгэрчилсэн журмын дагуу ажиллаж байгаа ба сувилахуйн албаны бүтцийн бүдүүвчийг ЭМ-ийн яамны Төрийн захиргаа удирдлагын газарт бичгээр хүргүүлсэн.
9	6.26 208	ЭМ-ийн сайд С.Ламбаа	Ажлын хэсэг байгуулах тухай	Эрдэм шинжилгээ сургалт эрхэлсэн дэд захирал Г.Пүрэвсүрэн	Эрүүл мэндийн статистик мэдээллийн санг боловсронгуй болгох ажлын хэсэгт орж, холбогдох журам, маягтад шинэчлэх саналаа өгч ажиллаж байна.
10	6.12 180	ЭМ-ийн сайд С.Ламбаа	Жагсаалт, журам батлах тухай	Эрдэм шинжилгээ сургалт эрхэлсэн дэд захирал Г.Пүрэвсүрэн	Эрүүл мэндийн даатгал хариуцсан мэргэжилтэн болоод бусад холбогдох албанд мэдэгдэж үйл ажиллагааны хэрэгжилтэд хяналт тавьж ажиллаж байна.
11	7.09 226	ЭМ-ийн сайд С.Ламбаа	Судалгаа явуулах тухай	Эрдэм шинжилгээ сургалт эрхэлсэн дэд захирал Г.Пүрэвсүрэн	Халдварт бус өвчнийг тандах судалгааны багт холбогдох мэргэжилтнүүд орж ажиллаж байна.
12	7.31 250	ЭМ-ийн сайд С.Ламбаа	Шагнах тухай	Хүний нөөцийн менежер П.Мөнхзул	Захирлын 2009 оны №111 тоот тушаал гарч, “Эрүүлийг Хамгаалахын Тэргүүний ажилтан” хүндэт тэмдгээр 3 ажилтан, “Эрүүлийг Хамгаалахын Хүндэт жуухаар” 7 ажилтанд тус тус шагнуулав.
13	10.06 1а/304 8	ЭМЯ	Хамтын хэлэлцээрийг хэрэгжүүлэх тухай	Хүний нөөцийн албаны дарга Д.Мөнхтуяа	Захиргаа, үйлдвэрчний эвлэлийн хороотой 9 зүйл бүхий хамтын гэрээг 2009.04.01-нээс 2 жилийн хугацаатайгаар байгуулан Баянзүрх дүүргийн засаг даргын тамгын газраар хянуулан бүртгэлийг хийлгэж, хагас бүтэн жилээр дүгнэн ажиллаж байна.
14	9.09 293	ЭМ-ийн сайд С.Ламбаа	Стратеги, үйл ажиллагааны төлөвлөгөө батлуулах тухай	Клиник эрхэлсэн дэд захирал Г.Навчаа, эмчилгээний чанарын менежер Д.Алтанцэцэг нарт	Хог хаягдлын менежментийг сайжруулах зорилгоор хог хаягдлыг ангилан ялгах уут, аюулгүй хайрцгаар хангаж, түр хадгалах байранд засвар хийж тохижуулан, хог хаягдлыг цуглуулж, тээвэрлэх үеийн аюулгүй ажиллагааг хангах зорилгоор тагтай тэргэнцрээр хангасан.

15	11.06 364	ЭМ-ийн сайд С.Ламбаа	Томуугийн цар тахлын үед эрүүл мэндийн байгууллагы удад халдвар хамгааллын дэглэмийг чанд мөрдүүлэх, эмч, ажилтнууды н эрүүл мэндийг дэмжиж, халдвар авахаас сэргийлэх тухай	Эмчилгээний чанарын менежер Д.Алтанцэцэг	Халдварын хяналтын зөвлөлийн 10сарын 24-ны хуралдаанаар тусгаарлах тасгийг байгуулсан ба 12 сарын 28-наас эхлэн эмчлүүлэгчдийг тусгаарлан эмчилж эхэлсэн. Шинээр хэвтэж байгаа эмчлүүлэгч төдийгүй эмнэлгийн эмч ажилчид, хэвтэн эмчлүүлэгч нарыг өдөр тутам томуугийн А хүрээний /H1N1/ вирусийн халдварын эмнэлзүйн шинж тэмдгээр тандалт хийн шаардлагатай арга хэмжээг авч тусгаарлан эмчилсэн. Мөн тусгаарлах тасагт ажиллах мэргэжлийн багийн эмч сувилагч үйлчлэгч нарыг томилсон “томуу томуу төст өвчний тандалтын баг зохион байгуулах” тухай төвийн захиралын 153 тоот тушаал гарсан. Ажилчдыг халдвараас хамгаалах биеийн эсэргүүцлийг сайжруулах зорилгоор эмнэлгийн өрөө тасалгааны халдваргүйтгэлийг сайжруулж нэмэлтээр гадаргуу-
					-ийн халдваргүйтгэлийг хийж эргэлтийг тасгуудын эргэлтийн хаалгаар оруулж,дуудлагын системийг бүрэн ажиллагаанд оруулсан. Халдвараас урьдчилан сэргийлэх талаар эмч ажилчдад сургалтыг төлөвлөгөөний дагуу 5 удаа давхардсан тоогоор 431 хүнд хийсэн байна.
16	11.06 365	ЭМ-ийн сайд С.Ламбаа	Хуваарь батлах тухай	Санхүү эдийн засгийн албаны дарга Х.Нарантуяа	Томуугийн А хүрээний /H1N1/ вирусын цар тахлын эмчилгээний 32857200 төгрөгийн үнэ бүхий, Германд үйлдвэрлэсэн сэхээн амьдруулахын амьсгалын аппаратыг тус төвийн үндсэн хөрөнгийн бүртгэлд авч, санхүү нягтлан бодох данс бүртгэлд оруулан тооцсон.
17	11.10 270	ЭМ-ийн сайд С.Ламбаа	Томуугийн халдварын үед жирэмсэн эмэгтэйд үзүүлэх эрүүл мэндийн тусламжийг чанаржуула х тухай	Клиник эрхэлсэн дэд захирал Г.Навчаа, эмчилгээний чанарын менежер Д.Алтанцэцэг нарт	Түр заавар боловсруулж эмч нарт танилцуулав. Төвийн ажиллагсдаас жирэмсэн, хөхүүл хүүхэдтэй эхчүүдийн судалгааг гаргаж, ажлын байранд сургалт явуулан, зөвлөмж өгч, хамгаалах нэг удаагийн хэрэгслээр ханган, нэн түрүүнд вакцинжуулалтанд хамруулахаар ЭМЯ-д мэдээллийг хүргүүлсэн.

18	11.16 383	ЭМ-ийн сайд С.Ламбаа	Хуваарь батлах тухай	Клиник эрхэлсэн дэд захирал Г.Навчаа, Санхүү эдийн засгийн албаны дарга Х.Нарантуяа нарт	2 утасны нэгийг дүн бүртгэлийн статистикийн ажилтанд, орон нутгаас хавдрын мэдээ тайлан авахад хэрэглэх зорилгоор, нөгөөг томуугийн А хүрээний (H1N1) шинэ вирусийн талаарх хариуцлагатай жижүүрийн мэдээг шуурхай хүргүүлэх зорилгоор эмнэлгээс шалтгаалах халдвараас сэргийлэх албанд суурилуулсан нь үр дүнтэй ашиглагдаж байна.
19	12.21 435	ЭМ-ийн сайд С.Ламбаа	Эрүүл мэндийн байгууллагу удад хяналт- шинжилгээ, үнэлгээ хийх журам батлах тухай	Эрдэм шинжилгээ сургалт эрхэлсэн дэд захирал Г.Пүрэвсүрэн	Тушаалаар заасан журмыг баталж байгууллагын улирал тутмын тайлан болоод ажил үнэлгээндээ мөрдлөг болгон ажиллаж байна.
Эрүүл мэндийн сайдын тушаал, албан даалгавар 100% биелэгдсэн.					